



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.02.25 № 339
танай _____-ы № _____-т


ХЭНТИЙ АЙМАГ БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА З.УУГАНЖАРГАЛ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу танай байгууллагын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг 1 төлбөрийн акт, 3 албан шаардлагын хамт хүргүүлж байна.

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг тогтоосон хугацаанд fas.audit.mn системд бүртгэн илгээж, аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр, нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Хавсралт *26* хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ж.ГАНБААТАР

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2026/102/НА-СТА-ТШЗ

Чингис хот
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390

Аудитор: Д.Эрдэнэтуяа
Утас: 99569599

Цахим хаяг: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР**

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.02.25 № 363
танай _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА З.УУГАНЖАРГАЛ
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Бор-өндөр сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр байна. Үүнд:

- ✓ “Баялаг говь” ХХК-д “Усан сан байгуулах, усны нөөцийн сав авах” ажил гүйцэтгэх гэрээний дагуу 2023 онд урьдчилан шилжүүлсэн 9,000.0 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах талаар арга хэмжээ аваагүй.
- ✓ Тайлант хугацаанд 6 ажилтанд олгосон цалинд ноогдох 4,447.4 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын тайланд дутуу тусгаж, тайлагнаагүй орхигдуулсан.
- ✓ Үндсэн үйл ажиллагааны зардлаас буудал, хоол, тэмцээн уралдааны зардал, эрсдэлийн сангаас шагнал урамшуулал, зураг төсвийн үнэ, бохирын шугамын засвар зэрэгт нийт 28,697.4 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.
- ✓ Тайлант онд нийгмийн бодлогын мэргэжилтэн Ц.Эсүжингийн харилцах дансанд 3,369.2 мянган төгрөгийг шагнал, тэмцээн уралдааны зардалд шилжүүлсэн боловч эд хариуцагчийн тайлан гаргаагүй, зарцуулалтыг нотлох анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч нягтлан бодох бүртгэл хөтөлсөн зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хууль болон санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус байгууллага нь тайлант онд 2,054,575.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагааны зардалд 1,918,301.0 мянган төгрөгийг зарцуулан, орон нутгийн төсөвт 136,274.0 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 138,296.3 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 45,287.4 мянган төгрөг, нийт 183,583.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 159,865.1 мянган төгрөгийг зарцуулж, 23,718.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар 212,839.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 167,325.5 мянган төгрөгийн 4 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, 3,369.3 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 42,144.9 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлжээ.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 144 арга хэмжээ тусгаж, 91.0 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	629,747,649.00	1,026,759,517.60
33	АВЛАГА	141,523,686.00	378,385,578.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	57,249.00	57,249.00
335	Бусад авлага	141,466,437.00	378,328,329.00
3351	Байгууллагаас авах авлага	141,033,220.00	35,104,620.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	433,217.00	343,223,709.00
34	УРЬДЧИЛГАА	144,250,000.00	245,298,890.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	101,048,890.00
3471	Урьдчилгаа тооцоо	144,250,000.00	144,250,000.00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	144,250,000.00	144,250,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	243,973,863.00	403,075,049.60
354	Хангамжийн материал	233,973,863.00	386,075,049.60
35410	Бичиг хэргийн материал	1,700,000.00	4,323,540.00
35420	Аж ахуйн материал	219,944,863.00	357,000,706.60
35430	Сэлбэг хэрэгсэл	-	1,650,000.00
35440	Түлш, шатах тослох материал	-	2,531,053.00
35450	Барилгын засварын материал	12,329,000.00	20,569,750.00
35600	Мал амьтад	10,000,000.00	17,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,229,008,352.32	1,149,599,125.30
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,229,008,352.32	1,149,599,125.30
392	Биет хөрөнгө	1,212,320,352.32	1,131,598,625.30
39201	Барилга, байгууламж, орон сууц	757,906,827.00	754,678,327.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(158,593,976.62)	(210,741,068.06)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	370,650,000.00	288,350,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(45,322,222.40)	(86,997,222.52)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	262,032,684.00	337,120,955.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	(131,993,958.79)	(117,637,036.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	84,833,000.00	65,168,700.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(55,406,202.69)	(40,657,846.63)
39209	Зам, гүүрийн байгууламж	13,558,100.00	3,478,200.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(12,425,366.32)	(2,653,044.03)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	31,600,000.00	31,600,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	205,843,642.00	190,664,792.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(110,362,173.86)	(80,776,132.39)
393	Биет бус хөрөнгө	16,688,000.00	18,000,500.00
39301	Програм хангамж	280,000.00	1,780,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(280,000.00)	(467,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	16,688,000.00	16,688,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,758,755,901.32	2,176,358,642.90
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	143,442,422.81
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	143,442,422.81
413	Өглөг	-	4,499,105.71
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	138,943,317.10
4136	Бусад өглөг	-	134,334,757.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	4,608,560.10
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,758,755,901.32	2,032,916,220.09
51	Засгийн газрын хувь оролцоо	-	-
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	93,160,636.81	93,160,636.81
51101	Өмч: - төрийн	93,160,636.81	93,160,636.81
512	Хуримтлагдсан үр дүн	1,422,886,249.03	1,697,046,567.80
51210	Өмнөх үеийн үр дүн	1,422,886,249.03	1,422,886,249.03
51220	Тайлант үеийн үр дүн	-	274,160,318.77
51300	Хөрөнгийн дажин үнэлгээний зөрүү	242,709,015.48	242,709,015.48
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,758,755,901.32	2,176,358,642.90

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,199,688,837.1	2,293,355,493.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	255,315,283.00	184,843,904.93
120	Нийтлэг татварын бус орлого	255,315,283.00	184,843,904.93
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	255,315,283.00	184,843,904.93
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	255,315,283.00	184,843,904.93
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,944,373,554.00	2,108,511,589.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	601,480,654.00	53,936,489.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	156,060,054.00	8,649,089.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	445,420,600.00	45,287,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,342,892,900.00	2,054,575,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,342,892,900.00	2,054,575,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,617,253,413.74	1,949,345,175.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,617,253,413.74	1,949,345,175.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,321,369,288.66	1,796,624,614.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	907,280,403.86	1,048,889,018.74
210101	Үндсэн цалин	511,739,223.86	587,134,087.37
210102	Нэмэгдэл	301,430,180.00	380,072,631.37
210103	Унаа хоолны хөнгөлөлт	70,190,000.00	73,420,000.00
210104	Урамшуулал	23,921,000.00	8,262,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	106,617,075.82	127,609,097.88
210201	Тэтгэрийн даатгал	73,371,356.82	88,504,645.20
210202	Тэтгэмжийн даатгал	9,266,831.43	10,324,113.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,642,245.90	5,473,218.03
210204	Ажилгүйдлийн даатгал	4,148,590.13	4,603,502.73
210205	Эрүүл мэндийн даатгал	15,188,051.54	18,703,618.21
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,081,415.24	46,307,289.94
210301	Гэрэл, цахилгаан	8,196,157.24	10,670,438.94
210302	Түлц, халаалт	32,740,880.44	32,454,653.00
210303	Цэвэр, бохир ус	4,144,377.56	3,182,198.00
2104	Хангамж, бараа материалын зардал	74,057,148.00	74,592,170.00
210401	Бичиг хэрэг	13,192,754.00	16,492,640.00
210402	Тээвэр, шатахуун	44,249,904.00	40,717,830.00
210403	Шуудан, хөлбоо, интернэтийн төлбөр	4,540,080.00	4,192,650.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариулгал	466,250.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ажуйн өд зүйлс	11,608,160.00	5,189,050.00
210408	Бараа материал акталсны зардал	-	8,000,000.00
2105	Нормативт зардал	-	1,199,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,199,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	48,715,915.28	34,489,230.58
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,391,399.99	2,033,399.88
210602	Тавилга	689,149.89	951,600.54
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	500,000.00	-
210604	Урсгал засвар	45,135,365.40	31,504,230.16
2107	Томилолт, зочны зардал	26,018,000.00	23,930,000.00
210702	Дотоод албан томилолт	26,018,000.00	23,930,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	152,177,603.00	6,854,294.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	144,453,672.00	5,357,444.40
210803	Даатгалын үйлчилгээ	366,050.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	535,524.00	499,124.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	225,493.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,190,000.00	350,000.00
210807	Газрын төлбөр	406,864.00	559,726.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	961,421,727.46	432,754,013.41
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	817,286,687.00	237,969,461.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,131,000.00	4,358,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хөрогдол	136,004,040.46	190,426,552.41
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	295,884,125.08	152,720,560.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,804,570.00	16,446,500.43
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	8,250,000.00
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	37,048,045.00	8,196,500.43
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,756,525.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	253,079,555.08	136,274,059.82
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	253,079,555.08	136,274,059.82
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	582,435,423.26	344,010,318.73
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,655,000.00	69,849,999.96
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,655,000.00	69,849,999.96
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,655,000.00)	(69,849,999.96)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	580,780,423.26	274,160,318.77

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,967,173,284.00	2,238,158,809.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,967,173,284.00	2,238,158,809.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	624,280,384.00	183,583,709.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	178,859,784.00	8,649,089.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	445,420,600.00	174,934,620.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,342,892,900.00	2,054,575,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,342,892,900.00	2,054,575,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,884,873,284.00	2,237,158,809.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,884,873,284.00	2,237,158,809.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,456,955,638.92	2,060,996,129.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	898,144,067.77	1,140,654,788.29
210101	Үндсэн цалин	504,198,653.77	688,216,279.92
210102	Нэмэгдэл	298,830,399.00	372,346,208.37
210103	Унаа хоолны хөнгөлөлт	71,207,651.00	71,830,000.00
210104	Урамшуулал	23,907,364.00	8,262,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	115,803,660.91	125,804,762.95
210201	Тэтгэврийн даатгал	79,730,739.68	86,752,511.54
210202	Тэтгэмжийн даатгал	10,366,023.23	10,324,112.71
210203	ҮОМЦО-ний даатгал	5,064,012.15	5,473,218.03
210204	Ажилгүйдлийн даатгал	4,128,579.13	4,603,502.64
210205	Эрүүл мэндийн даатгал	16,514,306.72	18,651,418.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,081,415.24	46,307,289.94
210301	Гэрэл, цахилгаан	8,196,157.24	10,670,438.94
210302	Түлш, халаалт	32,740,880.44	32,454,653.00
210303	Цэвэр, бохир ус	4,144,377.56	3,182,198.00
2104	Хангамж, бараа материалын зардал	60,359,493.00	58,081,030.00
210401	Бичиг хэрэг	16,691,800.00	8,655,300.00
210402	Тээвэр, шатахуун	31,293,054.00	39,399,130.00
210403	Шуудан, холбоо, ингэрвэтийн төлбөр	4,422,080.00	4,159,650.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	466,250.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,486,309.00	5,866,950.00
2105	Нормативт зардал	922,000.00	1,178,000.00
210503	Нормын хувцас, зоолон эдлэл	922,000.00	1,178,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	122,756,870.00	135,358,850.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	54,478,480.00	92,764,600.00
210602	Тавилга	7,741,900.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	896,000.00	-
210604	Урсгал засвар	59,640,490.00	42,594,250.00
2107	Томилголт, зочны зардал	26,136,000.00	23,930,000.00
210702	Дотоод албан томилголт	26,136,000.00	23,930,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	179,442,603.00	57,256,558.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	171,853,672.00	55,627,708.00
210803	Даатгалын үйлчилгээ	366,050.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	535,524.00	499,124.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	225,493.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,055,000.00	482,000.00
210807	Газрын төлбөр	406,864.00	559,726.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,008,309,529.00	472,424,850.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	999,188,529.00	468,066,850.00
210902	Хячээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,121,000.00	4,358,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	427,917,645.08	176,162,679.82
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,804,870.00	16,170,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	8,250,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	37,048,045.00	7,920,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,756,825.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	253,079,555.08	136,274,059.82
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	253,079,555.08	136,274,059.82
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	132,033,220.00	23,718,620.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	132,033,220.00	23,718,620.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	82,300,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	82,300,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	82,300,000.00	-
223001	Бусад хөрөнгө	82,300,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(82,300,000.00)	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
7	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
8	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,000,000.00
10			

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцоосний нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	93,160,636.81	242,709,015.48	1,422,886,249.03	1,758,755,901.32
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	93,160,636.81	242,709,015.48	1,422,886,249.03	1,758,755,901.32
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	93,160,636.81	242,709,015.48	1,422,886,249.03	1,758,755,901.32
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	93,160,636.81	242,709,015.48	1,422,886,249.03	1,758,755,901.32
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	93,160,636.81	242,709,015.48	1,422,886,249.03	1,758,755,901.32
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	274,160,318.77	274,160,318.77
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	93,160,636.81	242,709,015.48	1,697,046,567.80	2,032,916,220.09

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН				
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,054,575,100.0	1,918,301,040.18	136,274,059.8	93.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,054,575,100.0	1,918,301,040.18	136,274,059.8	93.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,035,823,600.0	1,902,131,040.18	133,692,559.8	93.43
210101	Үндсэн цалин	1,182,450,300.0	1,140,654,788.29	41,795,511.7	96.47
210102	Нэмэгдэл	662,261,200.0	688,216,279.92	(25,955,079.9)	103.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	339,757,100.0	372,346,208.37	(32,589,108.4)	109.59
210104	Урамшуулал	134,640,000.0	71,830,000.00	62,810,000.0	53.35
210105	Гэрээт ажлын хөлс	-	8,262,300.00	(8,262,300.0)	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,792,000.0	-	45,792,000.0	-
210201	Тэтгэврийн даатгал	135,806,200.0	125,804,763.0	10,001,437.1	92.64
210202	Тэтгэмжийн даатгал	92,348,300.0	86,752,511.5	5,595,788.5	93.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,864,500.0	10,324,112.7	540,387.3	95.03
210204	ҮОМШӨ-ний даатгал	5,432,200.0	5,473,218.0	(41,018.0)	100.76
210205	Ажилгүйдлийн даатгал	5,432,200.0	4,603,502.6	828,697.4	84.74
210205	Эрүүл мэндийн даатгал	21,729,000.0	18,651,418.0	3,077,582.0	85.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,647,500.0	46,307,289.9	9,340,210.1	83.22
210301	Гэрэл, цахилгаан	12,000,000.0	10,670,438.9	1,329,561.1	88.92
210302	Түлш, халаалт	37,647,500.0	32,454,653.0	5,192,847.0	86.21
210303	Цэвэр, бохир ус	6,000,000.0	3,182,198.0	2,817,802.0	53.04
210304	Байрны түрээс			-	
2104	Хангамж, бараа материалын зардал	68,311,000.0	56,161,049.0	12,149,951.0	82.21
210401	Бичиг хэрэг	10,000,000.0	8,655,300.0	1,344,700.0	86.55
210402	Тээвэр, шатахуун	43,000,000.0	37,479,149.0	5,520,851.0	87.16
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,478,400.0	4,159,650.0	318,750.0	92.88
210404	Ном, хэвлэл			-	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариут	1,045,000.0	-	1,045,000.0	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,787,600.0	5,866,950.0	3,920,650.0	59.94
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал			-	
2105	Нормативт зардал	4,807,200.0	1,178,000.0	3,629,200.0	24.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл			-	
210502	Хоол, хүнс			-	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,807,200.0	1,178,000.0	3,629,200.0	24.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	145,928,300.0	135,358,850.0	10,569,450.0	92.76
210601	Багаж, техник, хэрэгсэл	95,585,200.0	92,764,600.0	2,820,600.0	97.05
210602	Тавилга			-	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	943,100.0	-	943,100.0	-
210604	Урсгал засвар	49,400,000.0	42,594,250.0	6,805,750.0	86.22
2107	Томилолт, зочны зардал	26,000,000.0	23,930,000.0	2,070,000.0	92.04
210701	Гадаад албан томилолт			-	
210702	Дотоод албан томилолт	26,000,000.0	23,930,000.0	2,070,000.0	92.04
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах			-	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хур	81,479,500.0	56,527,450.0	24,952,050.0	69.38
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	77,356,500.0	54,898,600.0	22,457,900.0	70.97
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	622,800.0	-	622,800.0	-
210803	Даатгалын үйлчилгээ	1,014,300.0	-	1,014,300.0	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	536,400.0	499,124.0	37,276.0	93.05
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	245,600.0	88,000.0	157,600.0	35.83

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	740,400.0	482,000.0	258,400.0	65.10
210807	Газрын төлбөр	963,500.0	559,726.0	403,774.0	58.09
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж			-	
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх			-	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	335,393,600.0	316,208,850.0	19,184,750.0	94.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	330,844,700.0	311,850,850.0	18,993,850.0	94.26
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,548,900.0	4,358,000.0	190,900.0	95.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,751,500.0	16,170,000.0	2,581,500.0	86.23
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,751,500.0	16,170,000.0	2,581,500.0	86.23
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,250,000.0	8,250,000.0	-	100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,920,000.0	7,920,000.0	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,581,500.0	-	2,581,500.0	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,054,575,100.0	1,918,301,040.2	136,274,059.8	93.37
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,054,575,100.0	1,918,301,040.2	136,274,059.8	93.37
132001	Орон нутгийн төсвөөс	2,054,575,100.0	1,918,301,040.2	136,274,059.8	93.37
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,000,000.0	(1,000,000.0)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,000,000.0	(1,000,000.0)	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	34.0	34.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	9.0	9.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	15.0	15.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	6.0	6.00	-	100.00
620004	Гэрээт ажилтан	4.0	4.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	183,583,709.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	183,583,709.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	159,865,089.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,562,061.00
210401	Бичиг хэрэг	1,642,080.00
210402	Тээвэр, шатахуун	1,919,981.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	729,108.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	729,108.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	155,573,920.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	155,573,920.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	23,718,620.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	23,718,620.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	183,583,709.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	183,583,709.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	138,296,309.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	45,287,400.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Засаг даргын тамгын газар нь сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, иргэд, оршин суугчдынхаа амьдралын чанарыг дэмжсэн ухаалаг бодлого, оновчтой зохицуулалт бүхий шударга, шуурхай үйлчилгээг үзүүлэх зорилготой ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлд Засаг даргын ажлын албаны чиг үүргийг тусгасан байна. Үүнд:

- 67.1. Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын ажлын алба нь тамгын газар байх бөгөөд доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:
- 67.1.1. харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах;
- 67.1.2. Засаг даргын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах;
- 67.1.3. Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах;
- 67.1.4. хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох;
- 67.1.5. тамгын газрын бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;
- 67.1.6. төрийн захиргааны ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах;
- 67.1.7. тухайн шатны Хурлын хэвийн үйл ажиллагааг ханган үйлчлэх;
- 67.1.8. татварын алба хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардсан мэдээллийг гаргаж өгөх.

Тус байгууллага нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Татварын ерөнхий хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухайн хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад эрх зүйн актыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5-д “Төсвийн захирагч тухайн жилийн батлагдсан төсвийг зохистой удирдаагүйн улмаас авлага, өр төлбөр үүсгэсэн нь албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно” гэсэн заалт нэмэгдэж өөрчлөлт орсон байна. Байгууллагын бусад үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Хэнтий аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг бөгөөд аймгийн Засаг даргын баталсан 2025 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 12 дугаар удирдамжийн хүрээнд Бор-Өндөр сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн байна. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын ажлыг аудитад ашиглахгүй гэж шийдвэрлэсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бор-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бор-өндөр сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,808,981.5 мянган төгрөгөөр буюу 11.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
A	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	141,523.69	378,385.58	236,861.89
Урьдчилгаа	144,250.00	245,298.89	101,048.89
Бараа материал	243,973.86	403,075.05	159,101.19
Үндсэн хөрөнгө	1,229,008.35	1,149,599.12	(79,409.23)
Нийт хөрөнгө	1,758,755.90	2,176,358.64	417,602.74
Өр төлбөр	0.00	143,442.42	143,442.42
Засгийн газрын оруулсан капитал	93,160.64	93,160.64	-
Өмнөх оны үр дүн	1,422,886.25	1,422,886.25	-
Тайлант оны үр дүн		274,160.32	274,160.32
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	242,709.01	242,709.01	-
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,758,755.90	2,176,358.64	417,602.74

Дээрх хүснэгтээс харахад:

- Тус сумын Засаг даргын тамгын газрын нягтлан бодогч О.Мөнхцэцэг нь хувийн харилцах дансанд болон аж ахуй нэгж, иргэний харилцах дансаар дамжуулан анхан шатны баримтгүй шилжүүлэн авсан 342,790.4 мянган төгрөгийг хувь хүнээс авах авлагаар, өмнөх оны үлдэгдлийн 11,443.2 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн 23,718.6 мянган төгрөг, нийт 35,161.6 мянган төгрөгийг байгууллагаас авах авлагаар тусгасан байна.
- Урьдчилгаа дансны үлдэгдэл 101,048.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь мөрийн хөтөлбөрийн зардлаас 6 арга хэмжээнд 78,645.8 мянган төгрөг, орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас 3 арга хэмжээнд 2,919.6 мянган төгрөг, эрсдэлийн сангаас 2 арга хэмжээнд 8,903.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны зардлаас 1 арга хэмжээнд 8,400.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсныг урьдчилж гарсан зардалд тусгасантай холбоотой байна.
- Тайлант онд 152,332.9 мянган төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр, 118,845.4 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, 112,077.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулан, 403,075.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- Тайлант онд 122,438.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 32,549.4 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, 242,300.1 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан байна.
- Дансны өглөгийн 143,442.4 мянган төгрөгийн үлдэгдэл нь нягтлан бодогч О.Мөнхцэцэгийн төрд учруулсан хохирлыг төлүүлэх тухай Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас тогтоосон 2025 оны №380125 дугаар бүхий төлбөрийн актын төлбөр 111,971.6 мянган төгрөг, Монголын цахилгаан холбоо ХХК-д 33.0 мянган төгрөг, Нийгмийн даатгалын хэлтэст 391.3 мянган төгрөг, Татварын хэлтэст 276.2 мянган төгрөг, бичиг хэргийн материалын өглөг 377.0 мянган төгрөг, тоног төхөөрөмжийн үлдэгдэл төлбөр 18,350.0 мянган төгрөг, ажил гүйцэтгэх гэрээний үлдэгдэл 3,600.0 мянган төгрөг, нийт 134,334.7 мянган төгрөгийг байгууллагад төлөх өглөгөөр, засаг даргын тамгын газрын барилгын цонхны засварын гэрээний үлдэгдэл төлбөр 4,608.3 төгрөгийг хувь хүнд өгөх өглөгөөр тусгасантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,791,511.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 20,345.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 1,811,857.1 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 242,718.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 2,054,575.1 мянга төгрөг батлагджээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 2,054,575.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,918,301.0 мянган төгрөг зарцуулж, 136,274.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,918,301.0 мянган төгрөг буюу 93.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 106,548.0 мянган төгрөг, баг, хорооны үйл ажиллагааны зардлыг 9,660.1 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардлыг 2,581.5 мянган төгрөг, орон нутгийн нөөц хөрөнгийн зардлыг 2,292.1 мянган төгрөг, эрсдэлийн сангийн нөөц хөрөнгийн зардлыг 192.2 мянган төгрөг, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг 15,000.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,301,669.20	1,195,121.15	106,548.05	91.81
80106	Баг, хорооны ҮАЗардал	383,358.60	373,698.48	9,660.12	97.48
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	10,501.50	7,920.00	2,581.50	75.42
80815	Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөг	8,250.00	8,250.00	-	100.00
81102	Орон нутгийн нөөц хөрөнгө	87,000.00	84,707.81	2,292.19	97.37
81103	Эрсдэлийн сангийн нөөц хөрөнгө	55,000.00	54,807.80	192.20	99.65
81518	Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээ	152,795.80	152,795.80	-	100.00
81549	Ахмадын сан	1,000.00	1,000.00	-	100.00
81701	Байгаль орчныг хамгаалах, нөхө	50,000.00	35,000.00	15,000.00	70.00
82801	Улсын их баяр наадам	5,000.00	5,000.00	-	100.00
	Нийт дүн	2,054,575.10	1,918,301.04	136,274.06	93.37

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэгдсэн судалгааны үр дүнгийн талаар:

1. Программ, хангамжийн бүртгэл, тайлагналтай холбоотой судалгаа: Санхүүгийн тайланд 1,500.0 мянган төгрөгийн СИ ТИ ЭС ХХК-ийн STSYSTEM 6.0.1 нягтлан бодох бүртгэлийн программ, 280.0 мянган төгрөгийн архив албан хэрэг хөтлөлтийн программ тус тус бүртгэлтэй байна. Ашиглалтын зардал гараагүй.
2. Байгууллагын орон тооны цомхотголын судалгаа: Тайлант онд 34 орон тоотойгоор, 1,182,450.3 мянган төгрөгийн цалингийн зардал баталсан байна. Гүйцэтгэлээр 32 орон тоотой 1,150,759.0 мянган төгрөгийн цалин олгосон байна. Орон тооны цомхотгол хийгдээгүй байна.
3. Унаа, хоолны хөнгөлөлтийн судалгаа: Хоолны хөнгөлөлтийг Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн алба хаагчид нөхөн төлбөр олгох тухай журам"-ын 8.4-т "Төрийн албан хаагчийн өдрийн хоолны зардлын тодорхой хэсгийг байгууллагаас нөхөн олгоно." гэсэн заалтыг үндэслэн ЗДТГ-ын даргын 2024 оны Б/01 тоот тушаалаар өдрийн 10.0 мянган төгрөгөөр тогтоон олгож байна. Тайланд онд хоолны хөнгөлөлтөд 134,640.0 мянган төгрөг батлагдснаас гүйцэтгэлээр 59,605.3 мянган төгрөг зарцуулсан байна.
4. Гадаад томилолт, арга хэмжээнд зарцуулсан зардлын судалгаа: Тайлант онд гадаад томилолт, арга хэмжээний зардал гаргаагүй.

5. Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнд зарцуулсан зардлын судалгаа; Тайлант онд орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас 1,700.0 мянган төгрөгийг өрхийн эрүүл мэндийн төвүүдийн зөвлөгөөн, 1,000.0 мянган төгрөгийг бүсийн боловсролын байгууллагуудын зөвлөгөөн, 688.6 мянган төгрөгийг малчдын зөвлөгөөнд тус тус зарцуулсан байна.
6. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн судалгаа; Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай гэрээ байгуулаагүй.
7. Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардлын судалгаа; Тайлант онд төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.

Судалгааны үр дүнд зөрчил илрээгүй болно.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 138,296.3 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 45,287.4 мянган төгрөг, нийт 183,583.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж хангамж, бараа материалын зардалд 3,562.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 729.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 155,573.9 мянган төгрөгийг тус тус зарцуулж үлдэгдэл 23,718.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Эрдэнэтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Ж.Ганбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Бор-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 55 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,617,253.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 26,172.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 19,629.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзэв

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/59 дүгээр тушаалаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд тавих бодлого, чиглэл”, А/89 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ыг баталсан.

Дээрх бодлого чиглэл, зааврыг хэрэгжүүлж, шалгагдагч байгууллагад хамааралтай 29 шалгуур үзүүлэлтийн дагуу горим сорилыг гүйцэтгэхэд алдаа зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторовн дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд мэдээлбэл зохих мэдээллийг бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовн баталсан удирдамжийн дагуу 2025 оны 9 дүгээр сард тус байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, холбогдох үндсэн хөрөнгө, бараа материал, мөнгөн хөрөнгийн баримтыг хамруулан завсрын аудитыг гүйцэтгэсэн.

Завсрын аудитаар санхүүгийн анхан шатны баримтын бүрдлийг хангах, авлага, урьдчилж гарсан зардлыг бүрэн бүртгэх, үндсэн хөрөнгө бараа материалын бүртгэл, тооллого, Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтэй холбоотой 234,604.1 мянган төгрөгийн 5 зөвлөмжийг асуудлын бүртгэлээр танилцуулан баталгаажуулсан.

Тайлант хугацаанд нягтлан бодогч О.Мөнхцэцэг нь нийт 230,815.8 мянган төгрөгийг өөрийн хувийн харилцах болон 1 иргэн, 1 аж ахуй нэгж байгууллагын харилцах дансанд дэнчин, нийгмийн даатгалын шимтгэл гэсэн гүйлгээний утгатайгаар шилжүүлсэн нь гэмт хэргийн шинжтэй нөхцөл байдал үүссэн тул Прокурорын байгууллагад шилжүүлэх саналыг аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовн 2025 оны 9 дүгээр сарын 08 өдрийн 670 дугаар албан бичгээр Монгол улсын ерөнхий аудиторт уламжилсан.

Дээрх саналыг үндэслэн Монгол улсын ерөнхий аудитор 2025 оны 11 дүгээр сарын 03 өдрийн 3110 дугаар албан бичгээр “Гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй нөхцөл байдлыг шалгуулах, хэрхэн шийдвэрлэсэн талаар хуульд заасны дагуу хариу мэдэгдэх хүсэлтийг Монгол улсын ерөнхий прокурор, төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх Б.Жаргалсайхан-д хүргүүлсэний дагуу Монгол улсын ерөнхий прокурорын газраас Авлигтай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэст шилжүүлсэн байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 6,326.3 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосныг төлж барагдуулсан, 1,471.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг хугацаанд нь ирүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	6,326.3	1	6,326.3	100.0
Албан шаардлага	1	1,471.0	1	1,471.0	100.0
Нийт дүн	2	7,797.3	2	7,797.3	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Авлагын дансны барагдуулалтыг авч үзнэ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 161,505.7 мянган төгрөгийн 4 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залрууллаа. Үүнд:

1. Соёлын төвийн засварын зураг төсвийн урьдчилгаанд 8,000.0 мянган төгрөгийн шилжүүлсэн боловч урьдчилж гарсан зардалд бүртгээгүй зардалд хаасан.
2. Засаг даргын нөөц хөрөнгө, Засаг даргын мөрийн хөтөлбөр, Эрсдэлийн сангаас худалдан авсан бусад байгууллагад хүлээлгэн өгөх 93,048.8 мянган төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, хүлээн авсан акт байхгүй, хүлээлгэж өгөөгүй.
3. Тайлант хугацаанд худалдан авсан 38,129.8 мянган төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгалгүй орхигдуулсан.
4. Зос хаан норов ХХК-аас нэхэмжилсэн 377.0 мянган төгрөгийн бичиг хэргийн зардал, Баянзаг динозавр ХХК-аас худалдан авсан онцгой байдлын тоног төхөөрөмжийн үлдэгдэл төлбөр болох 18,350.0 мянган төгрөг, Эко лэнд менежмент ХХК-тай байгуулсан ажил гүйцэтгэх гэрээний үлдэгдэл төлбөр 3,600.0 мянган төгрөг нийт 22,327.0 мянган төгрөгийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгалгүй орхигдуулсан.

Аудитаар нийт 45,514.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 3,369.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 42,144.9 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

1. Тайлант хугацаанд нийгмийн бодлогын мэргэжилтэн Ц.Эсүжингийн харилцах дансанд 3,369.2 мянган төгрөгийг шагнал, тэмцээн уралдааны зардалд шилжүүлж, анхан шатны баримтгүй зарцуулж, бэлэн мөнгөний гүйлгээний тайлан гаргаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 20 дугаар зүйлийн 20.1.4-т “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалт, нийцтэй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төлбөрийн актын биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор fas.audit.mn системд бүртгэн илгээж, аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр, нотлох баримтын хамт ирүүлэх

5.2 Албан шаардлага

1. Үндсэн үйл ажиллагааны зардлаас буудал, хоол, тэмцээн уралдааны зардал, эрсдэлийн сангаас шагнал урамшуулал, зураг төсвийн үнэ, бохирын шугамын засвар зэрэгт нийт 28,697.4 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-т “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт, нийцтэй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Баялагговь ХХК-д “Усан сан байгуулах, усны нөөцийн сав авах” ажил гүйцэтгэх гэрээний дагуу 2023 онд урьдчилан шилжүүлсэн 9,000.0 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах талаар арга хэмжээ аваагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”; 20.2.6-д “Эд

хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”; Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй” гэсэн заалт, нийцтэй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3. Тайлант онд 6 ажилтанд олгосон цалинд ноогдох 4,447.4 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын тайланд дутуу тусгаж, тайлагнаагүй орхигдуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.2-д “Орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх”, 32.2.3-д “Нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, мэдээг гарган энэ хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д заасан хугацаанд нийгмийн даатгалын байгууллагад хүргүүлэх”; гэсэн заалт, нийцтэй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Албан шаардлагын биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор fas.audit.mn системд бүртгэн илгээж, аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр, нотлох баримтын хамт ирүүлэх

5.3 Зөвлөмж

Байхгүй.

Аудитаар илрүүлсэн 45,514.1 мянган төгрөгийн зөрчил болон хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн 230,815.8 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Урьдчилж гарсан зардлыг зардалд бүртгэсэн.	2	101,048.8	2	101,048.8			2	101,048.8				
Хөрөнгө бүртгээгүй орхигдуулсан	1	38,129.8	1	38,129.8			1	38,129.8				
Өглөг тусгаагүй орхигдуулсан	1	22,327.0	1	22,327.0			1	22,327.0				
Дүн	4	161,505.7	4	161,505.7			4	161,505.7	0	0,00	0	0,00

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Мөнгөн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан	1	28,697.4			1	28,697.4						
НДШ -ийн тайланд цалинг дутуу тусгаж орхигдуулсан	1	4,447.4			1	4,447.4						
Авлагыг тооцоо нийлээгүй.	1	9,000.0			1	9,000.0						
Анхан шатны баримтгүй зарцуулсан	1	3,369.2	1	3,369.2								
Гэмт хэргийн шинжтэй нөхцөл байдал үүссэн					3	42,144.9						
Дүн	4	45,514.1	1	3,369.2	3	42,144.9						



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 36-А2371125

Чингис хот

ХЭА - 2026/102/НА-СТА - ТШЗ

Г

Төлбөр барагдуулах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд нийгмийн бодлогын мэргэжилтэн Ц.Эсүжингийн харилцах дансанд 3,369,269.00 (гурван сая гурван зуун жаран есөн мянга хоёр зуун жаран ес) төгрөгийг шагнал, тэмцээн уралдааны зардалд шилжүүлж, анхан шатны баримтгүй зарцуулж, бэлэн мөнгөний гүйлгээний тайлан гаргаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8-т "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Анхан шатны баримтгүй зарцуулсан 3,369,269.00 (гурван сая гурван зуун жаран есөн мянга хоёр зуун жаран ес) төгрөгийг Засаг даргын тамгын газрын дарга З.Ууганжаргалаар төлүүлж аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг дарга З.Ууганжаргал-д хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Д.ЭРДЭНЭТУЯА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 23

Дугаар 58-А 237/125

Чингис хот

ХЭА-2026/102/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагын Бор-Өндөр сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баялагговь ХХК-д “Усан сан байгуулах, усны нөөцийн сав авах” ажил гүйцэтгэх гэрээний дагуу 2023 онд урьдчилан шилжүүлсэн 9,000,000.00 (есөн сая) төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах талаар арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”; 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”; Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.7-д “Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулдаггүй, барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг дарга З.Ууганжаргал, нягтлан бодогч Д.Болортуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР



Ж.ГАНБААТАР
Д.ЭРДЭНЭТУЯА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 23

Дугаар 57-А/2371125

Чингис хот

ХЭА-2026/102/НА-СТА-ТШЭ

Г Зөрчил таслан зогсоох тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндсэн үйл ажиллагааны зардлаас буудал, хоол, тэмцээн уралдааны зардал, эрсдэлийн сангаас шагнал урамшуулал, зураг төсвийн үнэ, бохирын шугамын засвар зэрэгт нийт 28,697,440.00 (хорин найман сая зургаан зуун ерэн долоон мянга дөрвөн зуун дөч) төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-т "төсвийг зориулалт бусаар зарцуулсан," гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг зориулалт бусаар зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг даргын тамгын газрын дарга З.Ууганжаргал-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР



Ж.ГАНБААТАР
Д.ЭРДЭНЭТУЯА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 23

Дугаар 59-А 2371125 Чингис хот
ХЭА-2026/102/НА-СТА-ТШ 8

Г Зөрчил таслан зогсоох тухай 7

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 6 ажилтанд олгосон цалинд ноогдох 4,447,426.45 төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын тайланд дутуу тусгаж, тайлагнаагүй орхигдуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.2-д "Орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх", 32.2.3-д "Нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, мэдээг гарган энэ хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д заасан хугацаанд нийгмийн даатгалын байгууллагад хүргүүлэх"; гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ажилчдын цалинг нийгмийн даатгалын тайланд дутуу тайлагнадаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг дарга З.Ууганжаргал, нягтлан бодогч Д.Болортуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР



Ж.ГАНБААТАР
Д.ЭРДЭНЭТУЯА